



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/531

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 135 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,537,827.50 (таван сая таван зуун гучин долоон мянга найман зуун хорин долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Сүхбаатар дүүргийн 109 цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн 135 дугаар цэцэрлэг (А.Анхмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 109 дүгээр цэцэрлэг (Т.Мөнхтуул)-т, үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10-р дугаар сарын 11-ны өдрийн АЗД дугаар тушаалын хавсралт

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн 135 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжээ	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Хүүхдийн ширээ	11/2/2017	ш	11	79,802.50	877,827.50	632,767.48	245,060.02	Сүхбаатар дүүргийн 109 дүгээр цэцэрлэг
2	Ширээ /3-4 настай/ 2023	10/010/2023	ш	5	118,000.00	590,000.00	79,895.79	510,104.21	
3	Сандал /4/5 настай/ 2023	10/10/2023	ш	30	58,000.00	1,740,000.00	235,625.00	1,504,375.00	
4	Ширээ /4-5 настай/ 2023	10/10/2023	ш	5	118,000.00	590,000.00	79,895.79	510,104.21	
5	Сандал /3-4 настай/ 2023	10/10/2023	ш	30	58,000.00	1,740,000.00	235,625.00	1,504,375.00	
Тавилга, эд хогшлийн дүн					431,802.50	5,537,827.50	1,263,809.06	4,274,018.44	